



**СЭНД ЭМ ЭН ББСБ ХХК-ИЙН  
ЭРСДЭЛИЙН УДИРДАГЫН БОДЛОГО**

2024 ОН



Баримт бичиг код: SE/BD/IA/POL/01/24  
Баримт бичиг нэр: Эрсдэлийн удирдлагын бодлого  
Хувилбар: 01  
Хянасан огноо: 2024  
Ангилал: Албан хэрэгцээнд

Хувилбар	Батлагдсан огноо, тушаалын дугаар	Өөрчлөлтийн тайлбар	Боловсруулсан	Хянасан
01		Анхны хувилбар боловсруулав	Дотоод аудит, эрсдэл хариуцсан менежер Б.Намуундарь	Эрсдэл, аудитын хороо, Гүйцэтгэх захирал Б.Төрболд

## АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ

ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ХЭМЖЭЭ

ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАРЧИМ

ЗУРГАА. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

НАЙМ. ДОТООД АУДИТ БА БАТАЛГААЖУУЛАЛТ

## **СЭНД ЭМ ЭН ББСБ ХХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү бодлогын зорилго нь “Сэнд Эм Эн ББСБ” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, өдөр тутмын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг тодорхойлох, үр ашигтай хяналтын тогтолцоог бий болгох, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарчмыг тодорхойлоход оршино.
- 1.2. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь компанийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн цар хүрээ буюу төрөл, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, эрсдэлийг хянах, үнэлэх, хариу арга хэмжээ авах, тайлагнах, удирдах бүтэц, чиг үүрэг, үйл явц болон тэдгээрийг зохицуулах бодлого, журам, заавар, аргачлалаас бүрдэнэ.
- 1.3. Эрсдэлийн удирдлагын бодлого нь компанийн нийт ажилтан болон бүхий л процесс, шийдвэр гаргалтад хамааралтай бөгөөд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой баримт бичиг юм.
- 1.4. Компани нь энэхүү бодлогыг хэрэгжүүлэхдээ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн үйл ажиллагаа зохицуулалтын журам болон бусад Монгол Улсын холбогдох хууль эрх зүйн акт болон эрсдэлийн удирдлагын олон улсын стандартад нийцүүлэн ажиллана.
- 1.5. Энэхүү бодлогод оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо (цаашид “Хороо” гэх)-ны саналыг үндэслэн ТУЗ батална.
- 1.6. Нэр томъёоны тайлбар:
  - 1.6.1. “Эрсдэл” гэж компанийн зорилго, зорилтод эерэг болон сөргөөр нөлөөлөх тодорхой бус үйл явдлыг;
  - 1.6.2. “Бизнесийн нэгж” гэж “Сэнд Эм Эн ББСБ” ХХК-ийн алба, баг, салбарыг;
  - 1.6.3. “Эрсдэлийн соёл” гэж компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудын эрсдэлийн удирдлагын ач холбогдлыг бүрэн танин мэдэж, эрсдэлийн удирдлагад оролцох өөрийн үүрэг, хариуцлагаа ойлгосны үндсэн дээр төлөвшсөн хандлага болон ур чадвар;
  - 1.6.4. “Эрсдэлийн гол үзүүлэлт” гэж эрсдэлийг удирдах явцад хянах шаардлагатай гол үзүүлэлт;
  - 1.6.5. “Эрсдэл даах чадвар” гэж зохицуулагч байгууллагаас тогтоосон хязгаарлалтуудаас хэтрэхгүй, одоогийн нөхцөлд тулгуурласан, хүлээн зөвшөөрч чадах эрсдэлийн дээд хэмжээг;

- 1.6.6. “Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ /Эрсдэлийн аппетит/” гэж компанийн бизнес төлөвлөгөө, стратегийн зорилтод хүрэхийн тулд хүлээн зөвшөөрч буй эрсдэлийн төрлүүд болон түвшнийг;
- 1.6.7. “Эрсдэлийн лимит” гэж компанийн хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор бизнесийн нэгжүүд, тусгай эрсдэлийн төрлүүд болон бусад түвшинд тархаан, нарийвчлан хуваарилсан ирээдүйд чиглэсэн тоон хэмжигдэхүүнийг;
- 1.6.8. “Ёс зүйн дүрэм” гэж компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын баг болон нийт ажилтнууд өдөр тутамдаа мөрдөж ажиллах ёс суртахууны хэм хэмжээ, мэргэжлийн ёс зүйтэй байдлыг тодорхойлсон баримт бичгийг ойлгоно.

## **ХОЁР. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО**

- 2.1. Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь “Хамгаалалтын 3 шугам”-ын зарчимд тулгуурлан бизнесийн зорилго, зорилттой уялдан хэрэгжинэ. Хамгаалалтын 3 шугамын дагуу оролцогч талууд дараах байдлаар эрсдэлийг зохих түвшинд удирдана. Үүнд:
  - 2.1.1. Хамгаалалтын 1-р шугам – Энэ шугамд эрсдэлийг хариуцаж удирдах эзэн буюу нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой гарах эрсдэлийг тодорхойлох, илрүүлэх, хариу арга хэмжээ авах, хяналтад байлгах, удирдах чиг үүрэг бүхий эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэгч нэгжүүд хамаарна.
  - 2.1.2. Хамгаалалтын 2-р шугам – Энэ шугамд эрсдэлийн удирдлагын тогтолцоог тодорхойлох, эрсдэлийн удирдлагын бодлого, журам, зааврыг боловсруулах, хянах, шинэчлэх, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, хязгаарыг тодорхойлох, батлуулах, хянах, мониторинг хийх чиг үүрэг бүхий эрсдэлийн удирдлагын хяналтыг хэрэгжүүлэгч нь буюу эрсдэлийн удирдлага хариуцсан ажилтан байна. Эрсдэлийн удирдлага хариуцсан ажилтан нь Хамгаалалтын 1-р шугамын эрсдэлийн удирдлага, хяналтын зохион байгуулалт, үйл ажиллагаанд мониторинг хийх, заавар, зөвлөмжөөр хангах үүрэгтэй.
  - 2.1.3. Хамгаалалтын 3-р шугам – Энэ шугам нь хараат бус баталгаажуулалтаар хангах Дотоод аудитын албанд хамаарна. Дотоод аудитын алба нь хамгаалалтын 1-р шугамын хэрэгжүүлж буй хяналтын тогтолцоо, түүний гүйцэтгэлийн хэрэгжилтэд хяналт тавих, дотоод хяналтын тогтолцоонд сайжруулах шаардлагатай сул талуудыг тодорхойлох, мөн хамгаалалтын 2-р шугамын тавьж буй хянан нийцүүлэлт, үнэлгээ, тайлагналын үр дүнтэй байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх ба эрсдэлд суурилсан үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлага, түүний засаглал, дотоод хяналтыг баталгаажуулж үнэлэх, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороонд тайлагнах чиг үүрэгтэй.
- 2.2. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэгч нэгжүүд нь Компанийн бизнесийн стратеги, бизнес төлөвлөгөө, төсөвт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхдээ өөрийн үйл ажиллагаатай холбоотой

эрсдэлийг хариуцан, бизнесийн үйл ажиллагааг эрсдэлийн удирдлагын бодлогод нийцүүлэн ажиллах ба Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээтэй нийцэж байгаа эсэхийг тогтмол хянан, баталгаажуулж ажиллана.

- 2.3. Эрсдэлийн удирдлагын хяналтыг хэрэгжүүлэгч (Эрсдэлийн удирдлага хариуцсан ажилтан) нь эрсдэлийн удирдлагын бодлогыг Компанийн стратеги зорилт, бизнес төлөвлөгөө, Монгол Улсын хууль, тогтоомж болон олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн сайжруулах, бодлого, журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэгч нэгжүүдэд сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, түүний үр ашигтай байдал болон Компанийн үйл ажиллагааны эрсдэлийн төлөв эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ нь хязгаарын хүрээнд байгаа эсэхэд хараат бусаар хяналт тавьж ажиллана.
- 2.4. Дотоод аудитын алба нь эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хараат бус, бие даасан хяналтыг хэрэгжүүлж эрсдэлийн удирдлагын тогтолцоо, системийн зөв зохистой байдалд үнэлэлт, дүгнэлт өгч ажиллана.
- 2.5. Гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан нь компанид эрсдэлийг соёлыг төлөвшүүлж, ажилтан бүрийг ажил, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь чиглүүлэх ба энэхүү бодлогоор баталсан эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээний хүрээнд компанийн бизнесийн үйл ажиллагааг удирдан явуулна.

## **ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ**

- 3.1. Компанийн үйл ажиллагаа, бизнесийн тасралтгүй байдлыг хангахад учирч болзошгүй эрсдэлүүдийн дараах төрлүүд байна. Үүнд:
- 3.1.1. Стратегийн эрсдэл – Бизнесийн орчинд аюул эсвэл тодорхойгүй байдал тулгарснаас шалтгаалан компани нь бизнес төлөвлөгөө, стратегийн зорилтод хүрч чадахгүй байх эрсдэл бөгөөд үүнд өрсөлдөгчийн эрсдэл, өөрчлөлтийн эрсдэл, зохицуулалтын эрсдэл, улс төрийн эрсдэл зэрэг хамаарна.
- 3.1.2. Санхүүгийн эрсдэл – Үндсэн үйл ажиллагааны орлогоороо зардлаа санхүүжүүлж чадахгүй болох буюу санхүүгийн алдагдал хүлээх эрсдэлийг хэлэх бөгөөд үүнд зах зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, өөрийн хөрөнгийн эрсдэл зэрэг хамаарна.
- 3.1.3. Үйл ажиллагааны эрсдэл – Компанийн бизнесийн зорилтод сөргөөр нөлөөлж болзошгүй үйл ажиллагааны тохиромжгүй, доголдолтой байдал, ажилтан, систем болон гадаад хүчин зүйлсээс шалтгаалан үүсэх санхүүгийн болон санхүүгийн бус алдагдал хүлээж болзошгүй эрсдэлийг хэлэх бөгөөд үүнд процесс, хүний нөөц, мэдээлэл технологи болон гуравдагч талтай холбоотой бүхий л эрсдэл хамаарна.

- 3.1.4. Нийцлийн эрсдэл – Хууль тогтоомж, бодлого, дүрэм журам, ёс зүйн стандарт, компанийн дотоод бодлого зэрэг зөрчигдсөнөөс үүдэн нэр хүндээ алдах, тусгай зөвшөөрлөө хүчингүй болгуулах, торгууль, акт тавиулах зэрэг шийтгэл хүлээх эрсдэлийг хэлнэ.
- 3.1.5. Зээлийн эрсдэл – Компанийн зээлийн үүрэг гүйцэтгэгч эсвэл харилцагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас санхүүгийн алдагдал үүсэх эрсдэл бөгөөд үүнд зээл төлөгдөхгүй байх эрсдэл, төвлөрлийн эрсдэл зэрэг хамаарна.
- 3.1.6. Мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл – Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой мэдээллийн хөрөнгийн бүрэн бүтэн, хүртээмжтэй байдал, нууцлал алдагдах эрсдэлүүд хамаарна.
- 3.2. Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдал нь эрсдэлийн соёлоор хэмжигдэх бөгөөд үүнд оролцогч талуудын хамтын ажиллагаа, хариуцлагатай байдал, шийдвэр гаргалт чухал нөлөөтэй байна.
- 3.3. Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд оролцогч талууд бүгд өдөр тутамдаа компанийн ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллаж хариуцсан эрсдэлээ мэргэжлийн ёс зүйтэй удирдана.

#### **ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ХЭМЖЭЭ**

- 4.1. Компани нь Эрсдэл даах чадварын хүрээнд компанийн стратеги зорилт болон бизнес төлөвлөгөөндөө хүрэхэд хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн хэмжээг тодорхойлох ба үүнийг үйл ажиллагааны гүйцэтгэлийн зорилтоос тусдаа ялгаатай авч үзнэ.
- 4.1.1. Компанийн эзэмшилд байгаа санхүүгийн болон санхүүгийн бус нөөцүүд нь эрсдэл даах чадварыг илэрхийлнэ.
- 4.1.2. Санхүүгийн нөөц нь өөрийн хөрөнгө болон ашгаар, санхүүгийн бус нөөц нь ажилтнуудын ур чадвар, мэдлэг, мэдээллийн технологийн систем, дотоод бодлого, журам заавар, хяналт, тайлагналын системээр тодорхойлогдоно.
- 4.1.3. Компани нь олон улсын гэрээ конвенц, хууль болон зохицуулагч байгууллагын шаардлага, хязгаарлалтаас хэтэрсэн эрсдэлийг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд эрсдэл даах чадвар нь эдгээр хязгаарлалтаар хэмжигдэнэ.
- 4.2. Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ (Эрсдэлийн аппетит):
- 4.2.1. Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ нь компанийн бизнесийн болон стратеги төлөвлөгөөтэй уялдсан байх бөгөөд эрсдэл даах чадвараас хэтрэхгүй байна.
- 4.2.2. Хамгаалалтын 1-р шугам нь өөрийн чиг үүрэгтэй холбоотой хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжүүрийг эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээний хүрээнд тодорхойлж, мөрдөх ба хамгаалалтын 2-р шугам түүнд хяналт тавина.

4.2.3. Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ нь зах зээлийн нөхцөл байдал, компанийн бизнес шийдвэр гаргалттай уялдан, эрсдэл даах чадвараас хэтрэхгүйгээр тухай бүр өөрчлөгдөж болно.

#### 4.3. Эрсдэлийн лимит:

4.3.1. Эрсдэлийн хэмжээг зохистой түвшинд хадгалахын тулд эрсдэлийн лимитийг эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээний хүрээнд хариуцсан нэгж, ажилтны саналыг үндэслэн Эрсдэлийн удирдлага хариуцсан ажилтан боловсруулж, Гүйцэтгэх захирал батална.

4.3.2. Эрсдэлийн лимит нь эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээнд хил хязгаар тогтоох, түүнийг бизнесийн нэгжүүдэд тархаан хуваарилахад ашиглагдана.

4.3.3. Эрсдэлийн лимит нь хэмжигдэхүйц, ирээдүйд чиглэсэн, хоорондоо уялдсан байх шаардлагатай бөгөөд энэ нь эрсдэл даах чадвараас хэтэрсэн эрсдэлүүдээс компанийг хамгаалах ач холбогдолтой.

#### 4.4. Эрсдэлийн хэмжээ:

4.4.1. Эрсдэлийн хэмжээ нь эрсдэлийн лимит, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, эрсдэл даах чадварын хүрээнд байгаа эсэхийг эрсдэлийн үнэлгээг ашиглан тооцно.

4.4.2. Эрсдэлийн үнэлгээг тухайн эрсдэлүүдийн тохиолдох магадлал болон учруулах нөлөөлөлд суурилсан аргачлалаар хийх бөгөөд Эрсдэлийн удирдлага хариуцсан ажилтан нь үнэлгээний аргачлал, загварыг тухай бүр сайжруулж нэгжүүдэд үнэлгээ хийх заавар чиглэл өгч, хянаж ажиллана.

4.4.3. Эрсдэлийн үнэлгээг компанийн хэмжээнд хамгийн багадаа 1 жил тутамд Эрсдэлийн удирдлага хариуцсан ажилтан зохион байгуулж хийх бөгөөд эрсдэлийн үнэлгээний нэгтгэл, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлын тушаалаар батална.

4.4.4. Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн компанийн хэмжээнд гол эрсдэлүүдийг тодорхойлох бөгөөд эдгээрийг хянах, бууруулах зорилгоор эрсдэлийн лимит, хүлээн зөвшөөрөх хэм хэмжээнд өөрчлөлт оруулж болно.

### **ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАРЧИМ**

5.1. Үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийг сайжруулж, компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлэх үүднээс эрсдэлийн удирдлагын дараах зарчмыг баримтална. Үүнд:

5.1.1. Үнэ цэнийг бий болгох – Эрсдэлийн удирдлага нь компанийн үнэт зүйлсийг сахин хамгаалах, хууль ёсыг дээдлэн, сайн засаглалыг бүрдүүлэх, стратегийн зорилгыг хэрэгжүүлж, өрсөлдөх чадвартай, үр ашиг бүхий, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй компанийг бий болгох хувь нэмрээ оруулдаг байх ёстой.

- 5.1.2. Харилцагчийн өмнө хүлээх үүрэг – Компани нь өөрийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тооцоолохоос гадна хувьцаа эзэмшигч болон нийт харилцагч, хамтрагч байгууллагуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг эрмэлзэж ажиллана.
- 5.1.3. Бүхий л үйл ажиллагааны салшгүй хэсэг байх – Эрсдэлийн удирдлага нь компанийн Гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтнуудын хариуцах ажил байхын зэрэгцээ өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөх, хянах үүрэгтэй байна.
- 5.1.4. Шийдвэр гаргах үйл явцын нэг хэсэг байх – Эрсдэлийн удирдлага нь ажилтнуудад мэдрэмжээрээ бус мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах, эрсдэлийг эрэмбэлэн, нэн чухал эсвэл нэн эрсдэлтэйг эхлэн шийдэх боломжийг олгоход чиглэнэ.
- 5.1.5. Шат дараалсан, уялдаа холбоотой, цаг хугацааны хэмжүүртэй байж тууштай, найдвартай бөгөөд эерэг үр дүнг бий болгоход чиглүүлж ажиллана.
- 5.1.6. Бодит байдалд суурилах – Эрсдэлийн удирдлага нь түүхэн мэдээлэл, бусад нэгжийн санал, ажиглалт, урьдчилсан таамаг болон, эрсдэлийн дүгнэлт зэрэг бодит мэдээллийг үндэслэх ба хэрэгжих боломжтой байна.
- 5.1.7. Уялдан зохицох – Гадаад болон дотоод орчны нөхцөл байдлаас шалтгаалж үйл явдал, эрсдэл өөрчлөгдөх магадлалтай. Иймд эрсдэлийг удирдах арга барилаа шинэчилж, сайжруулж ажиллана.
- 5.1.8. Ил тод байх – Компанийн ирээдүйд гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцоолж, мэдэгдэж буй бүх эрсдэлийн талаар ажилтан бүр мэдэж байгаа эсэхийг баталгаажуулна.
- 5.1.9. Бүх талуудын оролцоог хангах – Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд компанийн бүхий л ажилтнуудыг зохих байдлаар оролцуулна. Эрсдэлийн удирдлагыг компанийн гишүүн бүрд хамаатай болгох нөхцөлийг бүрдүүлэн, эрсдэлийг тодорхойлоход ажилтан бүр санал бодол, дуу хоолойгоо илэрхийлэх нөхцөлийг бий болгоно.
- 5.1.10. Эрсдэл, өгөөжийг тэнцвэржүүлэх – Компани нь бүхий л үйл ажиллагаандаа эрсдэл, өгөөжийн оновчтой харьцааг хадгалан, хяналт тавьж ажиллана.
- 5.1.11. Хараат бус, бие даасан байх – Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ хараат бус, хөндлөнгийн байр сууринаас үнэлж, дүгнэнэ.
- 5.1.12. Тайлагнах – Нэгжийн ажилтан бүр олж илрүүлсэн эрсдэлийг шууд удирдлагадаа шуурхай мэдээлдэг байна. Бүх шатны удирдлагууд өөрийн хариуцсан нэгж болон түүнд хамаарах үйл ажиллагаанд хамаарах эрсдэлийн тайланг Хамгаалалтын 2-р шугам болон эрсдэл хариуцсан нэгжид тогтмол, үнэн зөв тайлагнана.
- 5.1.13. Тасралтгүй сайжруулалт – Эрсдэлийн удирдлага нь суралцах, туршлагажих замаар байнга сайжирч байх ёстой. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх явцад үүсэх шинэ нөхцөл байдал, туршлага, алдаа, зөрчил, дутагдлыг тухай бүр тусган авч эрсдэлийн удирдлагын бодлогод шаардлагатай өөрчлөлтийг оруулж засаж сайжруулна. Мөн шинээр батлагдах хуулиуд, эрх

зүйн орчны болон бодлогын баримт бичгүүдийн өөрчлөлт зэрэгт тохируулж шинэчилж байх шаардлагатай.

5.2. Эрсдэлийн соёл – Компанийн нийт ажилтнууд нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам зааврыг дагаж мөрдөн, эрсдэлийн талаарх мэдлэг мэдээлэлтэй байх ба өөрийн хариуцсан ажил, чиг үүргийг хэрэгжүүлэхдээ учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, удирдах үүрэгтэй. Компани нь эрсдэлийн соёлыг бий болгоход нийт ажилтнуудад эрсдэлийг удирдах техникийн арга барилаас гадна эрсдэлд хандах хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалтыг зохион байгуулна.

## **ЗУРГАА. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

6.1. Компани нь эрсдэлийн удирдлагыг дараах процессоор хэрэгжүүлнэ.

6.1.1. Эрсдэлийн удирдлагын чиг хүрээг тодорхойлох – Эрсдэлийн удирдлагын чиг хүрээг тодорхойлж, эрсдэлийн төрөл, үйл ажиллагаанаас хамаарч эрсдэлийг хэрхэн илрүүлэх, үнэлэх, хариу арга хэмжээ авах, хянах төлөвлөгөө, чиг, хүрээг хамгаалалтын 1-р болон 2-р шугам хамтран тодорхойлно.

6.1.2. Эрсдэлийг илрүүлэх/тодорхойлох – Хамгаалалтын 1-р шугам нь өөрийн хариуцсан үйл ажиллагаа, чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тодорхойлох ба энэ үе шатанд илрүүлсэн эрсдэл бүрийг Эрсдэлийн бүртгэлд бүртгэж, Хамгаалалтын 2-р шугамд тухай бүр мэдээлж, тайлагнана.

6.1.3. Эрсдэлийн үнэлгээ – Илрүүлсэн буюу тодорхойлсон эрсдэл бүрийг компани удирдах боломжгүй тул Эрсдэлийг чанарын болон тоон үзүүлэлтээр үнэлэн эрсдэлийн түвшнийг тогтоож тухайн эрсдэлийг эрэмбэлэн хариу арга хэмжээ авах зэрэглэлийг тогтооно.

6.1.4. Эрсдэлийг эрэмбэлэх – Эрсдэлийн түвшнийг үндэслэн эрсдэлийн оноог тодорхойлох ба тухайн эрсдэлд хариу арга хэмжээ авах шаардлага болон эрэмбийг эрсдэлийн оноон дээр үндэслэн тодорхойлно.

6.1.5. Хариу арга хэмжээ – Компани нь олж илрүүлсэн эрсдэл, түүний үнэлгээнд үндэслэн эрсдэлээс хамгаалах хариу арга хэмжээг дараах чиглэлээр төлөвлөж, хэрэгжүүлнэ. Үүнд:

- Урьдчилан сэргийлэх буюу эрсдэл гарахаас хамгаалах, учрах магадлалыг бууруулах, сааруулахад чиглэсэн арга хэмжээ.
- Эрсдэлийг бууруулах буюу учирсан эрсдэлийн үр дагаврыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ.

6.2. Эрсдэлийг удирдахад эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг харгалзан үзсэний үндсэн дээр дараах арга хэмжээний аль нэгийг эсвэл хэд хэдийг хамтад нь хэрэгжүүлж болно.

Хариу арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ
-------------------	-------------------------

Эрсдэлээс хамгаалах	Эрсдэлээс зайлсхийх бус эрсдэлийг удирдах. Үр дүн нь ижил байх арга хэмжээ, эсвэл бусад арга замыг сонгож хэрэгжүүлэхгүй байхад анхаарах.
Эрсдэлийг бууруулах	Удирдлагын хяналт, үйл ажиллагааг сайжруулж, тохиолдох магадлалыг бууруулах
	Сөрөг үр дагаврыг боломжит бага түвшинд хүргэж бууруулах стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх – Жишээлбэл, нөөц төлөвлөгөө, бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө, гэрээний хариуцлагын хамгаалалт.
Эрсдэлийг шилжүүлэх	Гэрээний үндсэн дээр хариуцлагыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн нөгөө талд/гуравдагч этгээдэд, эсвэл даатгалд шилжүүлэх.
Эрсдэлийг зөвшөөрөх	Дотоод хяналт зохистой гэж үзсэн тохиолдолд эрсдэлийг хүлээн зөвшөөрөх ба хяналтыг тогтмолжуулж, нөөц төлөвлөгөөг шаардлагатай хэсэгт зориулан боловсруулах.

## ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

7.1. Компанийн нэгжүүд нь дараах чиг үүрэгтэйгээр оролцоно. Үүнд:

7.1.1. Төлөөлөн удирдах зөвлөл:

- Эрсдэлийн удирдлагын бодлогыг батлах, хүчингүй болгох, хэрэгжилтэд хяналт тавих;
- Эрсдэлийн лимит, хязгаарлалтуудаас хэтэрсэн, эрсдэлийн тохиолдлуудыг тухай бүр нь илрүүлэх, үр дүнтэйгээр удирдах, бууруулах арга хэмжээ зэргээр Эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрэн хэрэгжүүлэх үүрэг өгч, хэрэгжилтэд хяналт тавина.
- Компанид эрсдэлийн соёлыг төлөвшүүлэхэд манлайлж оролцоно.

7.1.2. Гүйцэтгэх захирал:

- Компанийн богино болон урт хугацааны стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, өөрийн хөрөнгийн төлөвлөлт, эрсдэл даах чадвар, зохицуулагч байгууллагаас тогтоосон хязгаарлалтуудад нийцтэй хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг батлах;
- Эрсдэлийн лимитүүдээс хэтэрсэн, эсвэл ойр байгаа материаллаг эрсдэлийн тохиолдлуудыг тухай бүр нь илрүүлэх, үр дүнтэйгээр удирдах, бууруулах зэргээр эрсдэлийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэхэд хяналт тавьж, чиглэл өгөх;
- Бизнесийн нэгжүүдийн эрсдэлийн лимитүүд, стратеги төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө, шийдвэр гаргах үйл явц нь эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээнд нийцтэй байгаа эсэхэд хяналт тавих;

- Эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хянах, тайлагнах процессыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд бизнес нэгжүүд дэмжих чадвартай эсэхэд хяналт тавих;
- Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашигт байдлыг хангахын тулд эрсдэлийн удирдлага, санхүү бүртгэл, мэдээллийн технологийн дэд бүтцийг бүх төрлийн нөөц, мэргэжилтнүүдээр хангах ажлыг зохион байгуулах
- Эрсдэлийн лимитүүдээс хэтэрсэн эсвэл хүлээлтээс давсан материаллаг эрсдэлийн тохиолдлуудыг цаг алдалгүй ТУЗ-д тайлагнах;
- Эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих.

#### 7.1.3. Дотоод аудитор:

- Компанийн хэмжээнд болон бизнесийн чиглэл, процесс бүрд Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг хараат бусаар үнэлж, үр дүнг гүйцэтгэх удирдлагад мэдээлж, Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнах;
- Эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах чиглэлд Хамгаалалтын 1-р болон 2-р шугамын нэгжүүдийг зөвлөмжөөр хангах;
- Үл зөвшөөрөх зөрчлийн шалтгааныг судлах, ашиглантай холбоотой ажилтнуудад авах арга хэмжээний санал бэлтгэж, Захиргаа, хүний нөөцийн алба болон Гүйцэтгэх удирдлагад танилцуулах;

#### 7.1.4. Эрсдэлийн удирдлага хариуцсан ажилтан (Хамгаалалтын 2-р шугам):

- Компанийн богино болон урт хугацааны стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, өөрийн хөрөнгийн төлөвлөлт, эрсдэл даах чадвар, зохицуулагч байгууллагаас тогтоосон хязгаарлалтуудад нийцтэй хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний төслийг боловсруулж Гүйцэтгэх захиралд танилцуулах;
- Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээ, эрсдэлийн хязгаарлалтуудыг ТУЗ-өөр батлуулах, биелэлтэд тогтмол хяналт тавьж, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороонд тайлагнах;
- Эрсдэлийг үнэлэх, хэмжих аргачлалуудыг хөгжүүлж, нэвтрүүлэх;
- Эрсдэлийн удирдлагын тайлагналыг тогтмол, үнэн зөв, бүрэн гүйцэд бэлтгэн хийж Гүйцэтгэх удирдлагад танилцуулах;
- Бизнес нэгжүүдийн эрсдэлийн хязгаарлалтуудыг эрсдэл даах чадвар, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээнд нийцтэйгээр боловсруулж, хэрэгжүүлж таниулах;
- Компанийн нийт ажилтныг эрсдэлийн удирдлагын чиглэлээр сургалт, мэдээллээр хангах;
- Эрсдэлийн лимитээс хэтэрсэн эсвэл ойр байгаа материаллаг эрсдэлүүдийг нэгжүүд үр дүнтэй удирдаж байгаа эсэхэд хяналт тавих;
- Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээнээс хэтэрсэн, компанийн санхүүгийн нөхцөл байдлыг дордуулах хэмжээний материаллаг эрсдэлийн тохиолдлыг эсвэл тохиолдохоор хүлээгдэж буй үед Гүйцэтгэх захиралд цаг алдалгүй мэдээлэх.

7.1.5. Хамгаалалтын 1-р шугамд хамаарах компанийн нэгжүүд:

- Өөрсдийн бизнес нэгжийн хүрээнд үр дүнтэй эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, эрсдэлийг илрүүлэх, хянах, тайлагнах, тогтолцоог бий болгох;
- Батлагдсан эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ болон бизнесийн нэгжийн төлөвлөгөө, шийдвэр гаргалтууд нь харилцан нийцтэй эсэхэд хяналт тавих;
- Компанид эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаандаа эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, эрсдэлийн лимитүүдийг дагаж мөрдөх;
- Эрсдэлийн удирдлага хариуцсан ажилтан болон Дотоод аудитын албаны хараат бус чиг үүргийг хүндэтгэн, үр дүнтэй хамтран ажиллах;
- Эрсдэлийн лимитүүдээс хэтэрсэн эсвэл хэтрэх боломжтой материаллаг эрсдэлүүдийг үр дүнтэй удирдах, бууруулах, эдгээр тохиолдлыг Гүйцэтгэх захирал болон эрсдэлийн удирдлага хариуцсан ажилтанд цаг алдалгүй мэдэгдэх;
- Хамгаалалтын 2-р шугамыг мэдээллээр хангаж ажиллах.

### **НАЙМ. ДОТООД АУДИТ БА БАТАЛГААЖУУЛАЛТ**

- 8.1. Дотоод аудит нь Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, түүний хэрэгжилтийн үр дүнтэй байдлыг хараат бус байдлаар баталгаажуулан, түүнийг сайжруулахад хувь нэмэр оруулах чухал хэсэг бөгөөд дотоод хяналтын үр дүнтэй ба үр ашигтай байдалд үнэлгээ хийх, тэдгээрийн байнгын сайжруулалтад дэмжлэг үзүүлэх замаар үр дүнтэй дотоод хяналтын системийг бий болгоход Компанид туслалцаа үзүүлнэ.
- 8.2. Дотоод аудит нь ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооноос баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Компанийн эрсдэлийн удирдлагын үр дүнтэй байдлыг үнэлж, Хамгаалалтын 1 болон 2-р бүсэд сайжруулах зөвлөгөө өгч ажиллана.